МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 30өдөр Дугаар А/454 Мөрөн сум

Гэрээ цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Иргэний хуулийн 219 дүгээр зүйлийн 219.1, 225 дугаар зүйлийн 225.1, 225.2, 227 дугаар зүйлийн 227.1, 254 дүгээр зүйлийн 254.1, Захиргааны ерөнхий хуулийн 56 дугаар зүйлийн 56.2, "Хог зөөвөрлөх машин худалдан авах /Тариалан сум/ бараа нийлүүлэх ХӨАОНӨГ/202312038-16 дугаартай гэрээний 15 дугаар зүйлийн 15.1.3 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч, "СүүХүнгий" ХХК-тай 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан "Хог зөөвөрлөх машин худалдан авах /Тариалан сум/ бараа нийлүүлэх ХӨАОНӨГ/202312038-16 дугаартай 87450000 (Наян долоон сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгийн үнэ бүхий гэрээг цуцлахаар шийдвэрлэсүгэй.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан "Хог зөөвөрлөх машин худалдан авах /Тариалан сум/ бараа ажил үйлчилгээ нийлүүлэх ажлын гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсоргодог)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712010958